

ЭРЭЛЧ НОХОЙН СУРГАЛТЫН ТӨВИЙН ДАРГА
БОЛДБААТАРЫН НАРАНБАДРАХЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. “ Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1.	Албаны эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөлийг сайжруулсан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, тоогоор	-	-Нохойн хоолны судалгаа хийж, холбогдох хууль журмын дагуу худалдан авах ажиллагаа зохион байгуулж, эрэлч нохдыг зориулалтын хоолоор хангах ажлыг эхлүүлнэ. -4 эрэлч нохойгоор гаалийн газар, хороодод нөхөн хангалт хийсэн байна.	1. Биелэлт: 1.1. ГЕГ-ын даргын 2024 оны 03 сарын 22-ны өдрийн № А/185 тоот “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг гаалийн байгууллагын эрэлч нохойн хэрэгцээнд шаардагдах зориулалтын хоол нийлүүлэх компанийг сонгон шалгаруулах зорилгоор 2024.04.05-ны өдөр ГЕГ/20240202002/02/01 урилгын дугаартай тендерийг зарласан. 2024 оны 04-р сарын 17-ны өдөр тендерийн сонгон шалгаруулалтад “Аз болор мөнх трейд” ХХК шалгарч гаалийн албаны эрэлч нохдод 2024	01.01-12.31	100

				онд хэрэглэх 10000 кг хоолыг нийлүүлсэн. 1.2. 2024 оны 11 дүгээр сарын 30 ний өдрийн байдлаар давхардсан тоогоор гаалийн албаны нийт 196 эрэлч нохойд урьдчилан сэргийлэх үзлэг, эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлсэн байна. Үүнээс: 1-р сард 10 нохой 2-р сард 11 нохой 3-р сард 11 нохой 4-р сард малын эмч байхгүй байсан учир үзлэг оношилгоо хийгдээгүй 9-р сард 6 нохой 10-р сард 27 нохой 11-р сард 20 нохой урьдчилан сэргийлэх үзлэг, асуумж болон эмчилгээнд хамруулан ажилласан. Эрэлч нохой өдөрт том нохойнд 750 гр, 1 жижиг нохойд 500 гр-р тооцож олгодог. Маллагч нар эрэлч нохдыг өдөрт 3-4 удаа тогтмол усалж, 1 нохойг өдөрт 30-60 минут зугаалуулж, 1-2 удаа хооллож, өдөр болгон үүрнүүд болон үүр орчмын талбайнуудыг цэвэрлэж, ариутгах, албаны нохдыг угаах, хатаах, самнах зэрэг ажлыг тогтмол хийсэн. 1.3. 2024 онд 3 нохдыг данс бүртгэлээс хасуулах, 2023 оны үржлийн хөтөлбөрийн дагуу шинээр бойжуулан авсан 4 гөлөг, шинээр авсан 1 нохойг данс бүртгэлд нэмж бүртгүүлэхээр холбогдох	
--	--	--	--	---	--

					материалыг бүрдүүлж 2024.09.19-ны өдөр 2024/63 тоот дотоод зурвасаар гаалийн ерөнхий газрын санхүү хөрөнгө, оруулалтын газар болон аж ахуй үйлчилгээний албанд хүргүүлж өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр хүргүүлсэн. Гаалийн ерөнхий газрын өмч хамгаалах зөвлөл асуудлыг дарааллын шийдвэрлэн хуралдаж байгаа боловч 2024 оны 11 дүгээр сарын 30 ний өдрийн байдлаар дээрх нохдын хурлын албан ёсны шийдвэр гараагүй хүлээгдэж байна. 1.4. 2024 онд харьяа гаалийн газар хороодод шинээр томилогдсон эрэлч нохой хариуцсан гаалийн улсын байцаагч нарт 9 эрэлч нохойгоор нөхөн хангалт хийж сургалтад хамруулан томилогдсон газар хороодод нь хүлээлгэн өгсөн. 1.5. 2024 оны 6-р сард ШХГГ-с ЭНХГУБ -аар нөхөн хангалт хийх хүсэлтийг ирүүлсэн. Уг хүсэлтийг ЭНСТ-ийн чиг үүргийн дагуу шийдвэрлэх боломжгүй тул ХНХ-т шилжүүлсэн. 2. Хүрсэн түвшин: 2.1. Гаалийн газар хороодод ажиллаж байгаа болон эрэлч нохойн сургалтын төвд байгаа эрэлч нохдыг анхан шатны тусламжийн багц, эм	
--	--	--	--	--	---	--

					тариа, хоолоор 100 хувь хангаж ажилласан. Эрэлч нохдод олгосон хоолны зарцуулалтын тайланг сар бүр нэгтгэн гаргаж аж ахуй, үйлчилгээний албаны нягтлан бодогч нарт хүргүүлдэг. 2.2. 2024 онд нохойн үзлэг оношилгооны тоо 2023 оны жилийн эцсийн байдалтай харьцуулахад 64 хувиар буурсан. Үүний гол шалтгаан нь 2024 онд малын эмчгүй ажилласан. 2023 онд газар хороодод ажиллаж байгаа эрэлч нохдын эрүүл мэнд, амьдрах орчны байдалд тандалт судалгаа, асуумжыг сар болгон авч ажиллаж байсан. 2024 онд тандалт судалгаа хийгдээгүй. Малын эмчгүй байх хугацаанд ЭНСТ-ийн ГУБ Б.Сарнай, А.Энх-Амгалан нар нохдод үзлэг оношилгоо эмчилгээ хийх ажлыг давхар хийж гүйцэтгэж байсан. Тайлант хугацаанд нохойн хорогдол байхгүй. Малын эмчийн дутуу орон тоог нөхөх санал хүсэлтийг холбогдох газар хэлтэст гарган ажиллаж байна. 2.3. Өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэр гарсаны дараа гаалийн байгууллага 53 эрэлч нохойтой болно. 2.4. 2024 онд эрэлч нохойн чиглэлээр шинээр томилогдсон 9 эрэлч нохой хариуцсан гаалийн	
--	--	--	--	--	---	--

					улсын байцаагчыг 100 хувь сургалтад хамруулсан. 5.2024.06.18 Шивээхүрэн ГГ-аас гаргасан нөхөн хангалт хийх хүсэлтийг ЭНСТ чиг үүргийн дагуу шийдвэрлэх боломжгүй тул ХНХ-рүү шилжүүлж холбогдох хариуг хүргүүлсэн.		
2.	Албаны эрэлч нохойн үржүүлгийн талаар хийгдсэн ажил	Хэрэгжилт, гүйцэтгэл, тоогоор	-	-2024 онд албаны шаардлага хангасан, эрүүл чийрэг нохдыг сонгож үржлийн хөтөлбөрийг боловсруулна -Үржлийн хөтөлбөрийн хүрээнд сонгогдсон нохойнуудыг нийллэгт оруулна.	1. Биелэлт: 1.1. 2024 оны үржлийн хөтөлбөрт хамрагдах нохойг сонгохдоо ГЕГ-ын нийт данс бүртгэлд байгаа 48 нохойноос судалгаа авч үржилд орох боломжтой 2-4 насны 19 ширхэг нохой байснаас 15 нохой нь эр хүйстэй, 4 нохой нь эм хүйстэй байсан. Үүнээс ЭНСТ дээр 2-4 насны 1 ширхэг эм нохой 4 ширхэг эр нохой байсан ч үүлдрийн хувьд таарахгүй болсон тул улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газарт ажиллаж байгаа Ноно дуудлагатай нохойг эрэлч нохойн сургалтын төвийн Коко дуудлагатай нохойтой 2024 оны 5-р сарын 1 нд нийллэгт оруулсан. Ноно нохойг тогтмол хяналтад байлгаж хэвлийг нь шалгахад хээл аваагүй нь тогтоогдсон. Охин нохойн ороо жилд 2 удаа ордог физиологийн онцлог байдлаас шалтгаалан өөр хос нохойг сонгох шаардлагатай болсон. СэГГ-ын Мики дуудлагатай эм нохойг ЧХОУНБГГ-ын Тони	01.01-12.31	100

				дуудлагатай эр нохойн хамт үржлийн хөтөлбөрт хамруулахаар сонгосон. Үржлийн хөтөлбөрт хамрагдсан ноход өнгө зүс, үүлдэр, бие бялдар сайн мал эмнэлгийн үзлэгт тогтмол хамрагдсан товлोलт вакцин, туулга бүрэн хийгдсэн. Тус ноход хяналтад орж тогтмол үзлэг шинжилгээ хийгдэж байсан. 2024 оны 07-р сарын 29-ний өдөр эм нохойны ороо орж 2 дахь 7 хоног буюу 8-р сарын 11-ний өдөр нийллэгт оруулсан . Охин нохой хээл авч 2024 оны 10-р сарын 10-ны өдөр төрж 4 гөлөг гаргасан. Төрсөн цагаас эхлэн “Гаалийн албаны эрэлч нохойн сонголт, нөхөн хангалт, бүртгэлжилтийг зохицуулах журам”-ын дагуу үзлэг оношилгоо, эмчилгээ, арчилгаа маллагаа, албаны идэвх суулгах, нийгэмшүүлэх ажлыг гөлөг бойжуулагч өдөр тутам зохион байгуулж тэмдэглэл хөтлөн ажиллаж байна. Гөлөгнүүд нь бүрэн дархлаа суугаагүй байдаг тул халдварт өвчин болон бактер, вирусийн халдвар авах магадлал өндөр байдаг тул халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг 45 хоногтойгоос эхлэн хийдэг. Нийт 3 тун вакциныг хийж бүрэн дархлаа тогтдог. Эхний тун вакциныг 2024 оны 12 сарын 03 нд хийсэн. Гөлөгнүүдэд 3 тун вакцин хийж		
--	--	--	--	---	--	--

				дархлаа бүрэн тогтох хүртэл гөлөг бойжуулагчаас бусад албан хаагчыг ойртож ажиллахыг хориглосон. 2. Хүрсэн түвшин: 2.1. 2024 оны Мики дуудлагатай лаборатор үүлдрийн нохойг үржлийн хөтөлбөрт амжилттай хамруулсан. Үржлийн хөтөлбөрийн үр дүнд лаборадори үүлрийн 4 гөлгөн нохойтой болсон. 2.2. 2023 онд гаалийн байгууллагын хэрэгцээнд малинуа үүлдрийн 4 гөлөг бойжуулан авсан бол 2024 онд лаборадори үүлдрийн 4 гөлгийг бойжуулан ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 30 ний өдрийн байдлаар гөлгөн нохойн эндэгдэл гараагүй. 2024 оны 4 гөлгийг эсэн мэнд бойжуулан авсанаар 2025 онд гаалийн байгууллага нийт 57 эрэлч нохойтой болохоор тооцсон. 2.3. 2024 оны 10-р сард БНСУ болон Монгол улсын гаалийн байгууллагуудын хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсад айлчилсан БНСУ-ын гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвийн албан хаагч нар дээрх 4 гөлөгнөөс өөрийн оронд аваачин ажиллуулах хүсэлтэй байгаагаа эрэлч нохойн сургалтын	
--	--	--	--	--	--

					төвийн дарга болон гадаад хамтын ажиллагааны дарга нарт илэрхийлсэн. БНСУ-ын гаалийн байгууллага нь лаборатори үүлдрийн нохой гаалийн хяналт шалгалтад гол төлөв ашигладаг бөгөөд эрс тэс уур амьсгалтай Монгол Улсад төрсөн лаборатори үүлдрийн нохойг сонирхож байгаа нь эрэлч нохойн сургалтын төвийн үржлийн хөтөлбөр үр дүнтэй амжилттай хэрэгжиж байгааг баталж байна.		
3.	Албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт	Зохион байгуулсан сургалтын тоогоор	-	2 удаагийн эрэлч нохойн сургалт зохион байгуулна.	1. Биелэлт: Тайлант хугацаанд анхан шатны сургалт 4, давтан сургалт 1, ажлын байран дээрх сургалт 1, цахим сургалт 1 нийт 7 удаагийн сургалтыг зохион байгуулан давхардсан тоогоор гаалийн байгууллагад эрэлч нохойн чиглэлээр ажилладаг давхардсан тоогоор 52 албан хаагчийн хамруулан ажилласан. Үүнд: 1.1. 2024 оны 1-р сарын 2 ний өдрөөс 2024 оны 2-р сарын 27 ний өдрийг хүртэл 42 хоног буюу 336 цагийн анхан шатны сургалтад 3 албан хаагч эрэлч нохойн хамт. 1.2. 2024 оны 1-р сарын 2 ний өдрөөс 2024 оны 2-р сарын 28 ний өдрийг хүртэл 42 хоног буюу 336 цагийн давтан сургалтад 3 албан хаагч эрэлч нохойн хамт.	01.01-12.31	100

				1.3. 2024 оны 2-р сарын 5 ний өдрөөс 2024 оны 3-р сарын 29 ний өдрийг хүртэл 40 хоног буюу 320 цагийн анхан шатны сургалтад 2 албан хаагч эрэлч нохойн хамт. 1.4. 2024 оны 3-р сарын 15 ний өдрөөс 2024 оны 5-р сарын 16 ний өдрийг хүртэл 45 хоног буюу 360 цагийн анхан шатны сургалтад 3 албан хаагч эрэлч нохойн хамт. 1.5. 2024 оны 7-р сарын 18 ний өдрөөс 2024 оны 7-р сарын 25 ний өдрийг хүртэл 7 хоног буюу 56 цагийн ажлын байрны сургалтад 5 албан хаагч эрэлч нохойн хамт. 1.6. 2024 оны 8-р сарын 26 ний өдрөөс 2024 оны 10-р сарын 25 ний өдрийг хүртэл 45 хоног буюу 360 цагийн анхан шатны сургалтад 3 албан хаагч эрэлч нохойн хамт. 1.7. 2024 оны 10-р сарын 23 ний өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан сургалтад 35 албан хаагчийг хамруулан ажлын байран дээр эрэлч нохойг сургаж дадлагажуулах арга хэлбэрийг зааж, эрэлч нохойн сургалтын төвөөс хэрэгжүүлж байгаа ажлуудыг танилцуулсан. 2. Хүрсэн түвшин: 2.1. 2024 онд эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан	
--	--	--	--	---	--

				сургалтын хөтөлбөрүүдийн дагуу 7 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор гаалийн байгууллагын 52 албан хаагчийг хамруулан ажилласан. Гаалийн ерөнхий газрын харьяа 13 газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа гаалийн улсын ахлах байцаагч 3, гаалийн улсын байцаагч 27, эрэлч нохой хариуцагч 3 нийт 35 албан хаагч, эрэлч нохойн сургалтын төвийн 3 албан хаагчийг эрэлч нохойн танхимын болон цахим сургалтад 100 хувь хамруулсан. 2023 оны жилийн эцэстэй харьцуулахад хамрагдсан албан хаагчийн тоо 15.5 хувиар нэмэгдэж, зохион байгуулсан сургалтын тоо 40 хувиар нэмэгдсэн байна. Сургалтын үр дүнд 2024 онд илрүүлсэн зөрчлийн тоо 2023 оноос 90 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2024 онд 5 удаа сургалт зохион байгуулахаар гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулсан, биелэлтээр 7 удаагийн сургалт зохион байгуулсан нь 40 хувиар өссөн үзүүлэлт болсон. Сургалтын тоо өсөх болсон шалтгаан нь 2023 оны 12-р сар болон 2024 онд шинээр томилогдсон эрэлч нохой хариуцсан ГУБ нартай холбоотой. 2.2. 2024 оны 08-р сарын 26 ний өдөр Монгол Улсын боловсролын	
--	--	--	--	---	--

				сайдын №А/249 тоот " Мэргэжлийн болон техникийн боловсролын мэргэжлийн чиглэл, индекс" баталсан тушаалаар батлагдсан. Албаны нохой сургагч мэргэшлийг: Ерөнхий чиглэл: 10 үйлчилгээ Төрөлжсөн чиглэл: 103 Аюулгүй байдлыг хангах Мэргэжлийн индекс: 103109 Мэргэжлийн чиглэл: Үндэсний аюулгүй байдлыг хангах ажиллагаа Мэргэшлийн түвшин: 2 Мэргэшлийн нэр: Нохой сургагч гэж ангилалд хамруулан чадамжийн нэгжээр тодорхойлж мэргэжлийн сургалтад ашиглахаар гэр бүл хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн холбогдох газар нэгжийн арга зүйч нарын хамт судалгаа хийж, заавар зөвлөгөө авч ажиллаж байна. Дээрх ангилалд хамаарагдвал чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг баталгаажуулан дүгнэлт гаргуулж албаны нохой сургах сургалтад ашиглаж эхэлнэ. Дээрх чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулахад гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн санаачлагаар 2021 2022 онд боловсруулж 2023		
--	--	--	--	--	--	--

					онд хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөр батлуулсан Монгол Улсын хэмжээнд мөрдөгдөх ажил мэргэжлийн стандартыг ашиглаж байна.		
4.	Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх, зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, хувиар, тоогоор	-	-Хяналт шалгалтад ашиглаж байгаа эрэлч нохойн тоог 8-аар нэмэгдүүлнэ.	1. Биелэлт: 1.1. 2024 онд гаалийн газар хороодод гаалийн хяналт шалгалтад ашиглаж байгаа нохойн тоог 10 аар нэмэгдүүлж нийт 33 эрэлч нохойтой болсон. Үүнд: 1. ЧХОУНБГГ-т 3 нохой 2. ДоГГ-т 2 нохой 3. ХаГГ-т 1 нохой 4. ЗүГГ-т 2 нохой 5. УБГГ-т 1 нохой 6. УвГГ-т 1 нохойтой болсон. Тус нохдыг эрэлч нохойн сургалтын төвийн даргын баталсан хөтөлбөрүүдийн дагуу хориглосон хязгаарласан барааг албаны нохойгоор олж илрүүлэх сургалтуудад хамруулсан. 1.2. Гаалийн ерөнхий газрын харьяа гаалийн газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нар сар бүр эрэлч нохой ашиглалтын мэдээг бэлтгэн гаалийн байгууллагын захиргаа, дотоод ажлын системд байршуулдаг. Уг мэдээнд ашиглагдаж байгаа эрэлч нохойн дуудлага, хяналт шалгалт хийсэн тоо, зөрчил илрүүлсэн тоо	01.01-12.31	100

				зэргийг багтаасан байдаг. Эрэлч нохойн сургалтын төвөөс сар бүр хүлээн авсан эрэлч нохой ашиглалтын мэдээг үндэслэн зөрчил илрүүлэлт болон ашиглалтыг хянадаг. 2024 оны 11-р сарын 30 ний өдрийн байдлаар гаалийн 13 газар хороодод ажиллаж байгаа 33 эрэлч нохой нийт 38 зөрчил илрүүлсэн. Үүнд: СэГГ - 17 зөрчил ЗҮГГ - 8 зөрчил УХШИГГ - 3 зөрчил ДоГГ - 2 зөрчил БөГГ - 3 зөрчил ЧХОУНБГГ - 5 зөрчлүүдийг илрүүлсэн байна. Илэрсэн зөрчлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу эрх бүхий албан тушаалтануудаар шийдвэрлүүлсэн. 1.3. Эрэлч нохдын зөрчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх, гаалийн хяналт шалгалтад ашиглах эрэлч нохдыг нэмэх зорилгоор хориглосон хязгаарласан бараа бүтээгдэхүүн, хар тамхи мансууруулах бодис зэргийг таньж илрүүлэх анхан шатны 4, давтан сургалт 1, ажлын байрны сургалт 1, цахим сургалт 1 зохион байгуулж давхардсан тоогоор 52 албан хаагчийг хамруулсан. Мөн албаны нохойн ажлын бүтээмжид шууд нөлөөлөх эрэлч нохдод шаардлагатай амин дэм эрдэс	
--	--	--	--	--	--

				витаминаар баялаг зориулалтын үйлдвэрийн хоол, эрүүл мэндэд шаардлагатай эм тариа, вакцин, туулга зэргийг газар хороодод тараасан. 2. Хүрсэн түвшин: 2.1. 2024 оны 11-р сарын 30 ний өдрийн байдлаар гаалийн байгууллагын данс бүртгэлд 48 эрэлч нохой бүртгэгдэн ажиллаж байна. Үүнээс 33 эрэлч нохой нь гаалийн 13 газар хороодод ажиллаж байна. Тус эрэлч нохдын ашиглалтыг сар болгоны 25 нд эрэлч нохой хариуцан ажилладаг албан хаагч нараас эрэлч нохой ашиглалтын мэдээг байнга хүлээн авсанаар эрэлч нохойн ашиглалтад тогтмол хяналт тавьж ажиллах нөхцлийг бүрдүүлж байна. 2.2. 2024 онд гаалийн 13 газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нар нийт 38 зөрчил илрүүлэн ажилласан нь 2023 оноос 90 хувиар өссөн үзүүлэлт болж байна. Шинээр томилогдсон албан хаагч нарыг эрэлч нохойн сургалтад 100 хувь хамруулсан. Гаалийн байгууллагад эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа 40 албан хаагч байгаагаас гаалийн 13 газар хороодод 35 албан	
--	--	--	--	--	--

					хаагч, эрэлч нохойн сургалтын төвд 5 албан хаагч ажиллаж байна. Гаалийн газар хороодод эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагч нарын тоо 2023 оны мөн үеэс 20 хувиар өссөн үзүүлэлттэй байна.		
5.	Бусад байгууллагатай хамтран ажилласан байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Гадаадын болон дотоодын нохой сургалтын төвүүдтэй туршлага солилцоно.	1.Биелэлт: Тайлант хугацаанд эрэлч нохойн чиглэлээр 2 удаа гаалийн газартай, 3 удаа төрийн бусад байгууллагатай, 2 удаа гадаад улс орны гаалийн байгууллагуудтай хамтран ажиллаж туршлага солилцсон.Үүнд: 1.1. 2024 оны 3-р сард ДГБ-с Хонгконг улсад зохион байгуулсан "эрэлч нохойн 6-р чуулга уулзалтад" Монгол Улсын гаалийн байгууллагаас 3 албан хаагч оролцсон. Чуулга уулзалтад 47 орны гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвийн 80 орчим төлөөлөгч оролцож өөрийн орны албаны нохой сургах онцлогуудын талаар туршлага солилцсон. 1.2. 2024 оны 5-р сард УХШИГГ-с 01/444 тоот албан бичгээр албаны нохой түр ажиллуулах хүсэлтийг ирүүлсэн. Уг хүсэлтийн дагуу 2024 оны 7-р сарын 3 ний өдөр гаалийн	01.01-12.31	100

				ерөнхий газрын хяналт бүрдүүлэлтийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу 2024 оны 9-р сарын 30 ний өдрийг дуустал эрэлч нохойн сургалтын төвийн 2 гаалийн улсын байцаагч эрэлч нохойн хамт ээлжлэн ажилласан. 1.3. 2024 оны 6-р сард тээврийн цагдаагийн албанаас № 13-4/349 тоот албан бичгээр гаалийн ерөнхий газрын дэд даргад эрэлч нохойн чиглэлээр дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах хүсэлтийг гаргасан. Уг хүсэлтийн дагуу ЧХОУНБуудал үүрэг гүйцэтгэсэн цагдаагийн албаны эрэлч нохдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулан, зориулалтын амрах үүрээр хангаж, албан хаагч нарт албаны нохойн арчлах, олон нийтийн ашиглахтай холбоотой заавар зөвлөгөөг тогтмол өгч хамтран ажилласан. 1.4. 2024 оны 8-р сард 421 дүгээр нээлттэй хорих ангиас №01/619 тоот албан бичгээр гаалийн ерөнхий газрын даргад эрэлч нохойн чиглэлээр дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах хүсэлтийг гаргасан. Уг хүсэлтийн дагуу тус ангийн дэд ахлагч Б.Давааг малинуа үүлдрийн нохойн хамт танхимын болон ажлын байран дээрх сургалтын арга зүйн	
--	--	--	--	--	--

				талаарх анхан шатны сургалтад хамруулсан. 1.5. 2024 оны 6-р сард ЗҮГГ-с 458 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийн дагуу гаалийн ерөнхий газрын дэд даргын 2024 оны 7-р сарын 2 ний өдөр баталсан хөтөлбөрийн дагуу ажлын байрны сургалт зохион байгуулсан. 1.6. 2024 оны 10-р сард албаны нохой-2024 тэмцээнийг зохион байгуулагдсан. Уг тэмцээнд гаалийн байгууллагын эрэлч ноход 2-р байр эзэлсэн. 1.7. 2024 оны 10-р сард Бүгд Найрамдах Солонгос Улсын гаалийн байгууллагатай хамтын ажиллагааны хүрээнд 2 орны албан хаагч нарыг солилцож эрэлч нохойн чиглэлээр туршлага солилцсон. 2. Хүрсэн түвшин: 2024 онд гаалийн ерөнхий газрын харьяа газар хороодтой 2 удаа, Монгол Улсын төрийн байгууллагуудтай 3 удаа, бусад улс орнуудтай 2 удаа, нийт 7 удаа бусад байгууллагуудтай хамтран ажилласан нь 2023 онтой харьцуулахад 7 дахин нэмэгдсэн байна. 2.1. Өдөр тутмын үйл ажиллагаандаа албаны нохой	
--	--	--	--	--	--

				ашигладаг Монгол Улсын төрийн байгууллагууд гаалийн байгууллагын эрэлч нохойн сургалтын төвийн материаллаг бааз, хүний нөөц, сургалтын арга аргачлалыг ашиглах сонирхолтой байгаа нь цагдаагийн ерөнхий газар болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын холбогдох газар хэлтсүүдтэй хамтран ажилласан ажлын үр дүнгээс харагдаж байна. 2.2. Дэлхийн гаалийн байгууллагаас зохион байгуулсан 6-р чуулга уулзалтад Монгол Улсын гаалийн байгууллага -35 градусаас +35 градусын хооронд нохойг сургаж бэлтгэн албанд ашиглаж чадаж байгаа нь сайн туршлага гэж Дэлхийн гаалийн байгууллагын төлөөлөгч болон хурал зохион байгуулагч нар онцолсон. Энэ эрэлч нохойн сургалтын төв өөрийн гэсэн онцлог сургалтын арга аргачлалтай болсоныг баталж байна. 2.3. 2024 оны 11-р сард Монгол Улсын гаалийн байгууллагад айлчилсэн БНСУ-ын гаалийн байгууллагын төлөөлөгч нар Монгол Улсын гаалийн байгууллагын үржлийн хөтөлбөрөөр гаргаж авсан лаборадор үүлдрийн нохой авах сонирхолтой байгаа, хамтарсан сургалт тэмцээн зохион		
--	--	--	--	--	--	--

					байгуулан оролцох хүсэлтэй байгаа тухайгаа илэрхийлсэн. 2.4. 2024 онд зохион байгуулагдсан албаны нохой-2024 тэмцээнд гаалийн байгууллагыг төлөөлөн оролцсон эрэлч ноход 2-р байр эзэлж амжилттай ороцсон. Мөн урд оны тэмцээнүүдэд 1-р эзэлж байсан нь гаалийн байгууллагын албаны нохой сургалтын үйл ажиллагаа Монгол Улсдаа тэргүүн зэргийг туршлага хуримтлуулсаныг баталж байна.		
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнана.	1. Биелэлт: 1.1. Эрэлч нохойн сургалтын төвөөс хуулийн хэлтэст 2024/77 тоот дотоод зурвасаар хандан эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаатай холбогдох Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын хорооны тогтоол Ерөнхийлөгчийн зарлиг, үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, тэмдэглэл, засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, засгийн газрын хуралдааны тэмдэглэл, ерөнхий сайдын албан даалгаварт холбогдох заалт байгаа эсэхийг тодруулсан. Хуулийн хэлтсээс 529 тоот дотоод зурвасаар гаалийн байгууллагад ирж байгаа Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын байнгын	01.01-12.31	100

					хорооны тогтоол Ерөнхийлөгчийн зарлиг, үндэсний аюулгүй байдлын зөвлөмж, тэмдэглэл, засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, засгийн газрын хуралдааны тэмдэглэл, ерөнхий сайдын албан даалгавар нь танай төвд хамааралтай бол тухайн бүр нь хүргүүлсэн байх ёстой тул энэ талаарх арга хэмжээг дотооддоо зохион байгуулан ажиллана уу гэсэн хариу ирсэн. 2024 оны тайлант хугацаанд эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбоотой бодлогын байгаагүй тул хэрэгжилт байхгүй бөгөөд шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг ханган ажиллаж хугацаанд нь тайлагнах болно. 2. Хүрсэн түвшин: 2.1. Тайлант хугацаанд Эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгт хамааралтай бодлогын баримт бичгүүд байгаагүй тул хэрэгжилтийг тайлагнаагүй бөгөөд шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг ханган ажиллаж, хугацаанд нь тайлагнах болно.		
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Холбогдох хууль тогтоомж эрх зүйн актын	1. Биелэлт:	01.01-12.31	100

			хэрэгжилтийг ханган ажиллана.	Тайлант хугацаанд эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаа, чиг үүрэгтэй холбогдох хууль тогтоомж, гаалийн ерөнхий газрын даргын баталсан дотооддоо дагаж мөрдөх эрх зүйн актуудыг албан хаагч нарт тайлбарлан таниулах ажлыг зохион байгуулж, мөн хэрэгжилтийг хангаж ажилласан.Үүнд: 1.1. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 6-р сарын 5 ний өдрийн А/107 тоот тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг зааварчилгаа”-ны дагуу албан хаагч нарт ажлын өглөө бүр аюулгүй ажиллагааны зааварчилгааг танилцуулж баталгаажуулалтын хуудас дээр гарын үсэг зуруулдаг. 1.2. Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 08 сарын 23 ний өдрийн А/176 тоот тушаалаар батлагдсан "Эрэлч нохойн сургалтын төвийн дүрэм"-ийг 2024 оны 3-р сарын 20 ний өдөр нийт албан хаагч нарт танилцуулсан. 1.3. Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны 10 сарын 24 ний өдрийн А/226 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ийг 2024 оны 3-р сарын 26 ний өдөр		
--	--	--	-------------------------------	--	--	--

				нийт албан хаагч нарт танилцуулсан. 1.4. Гаалийн ерөнхий газрын даргын 2022 оны А/204 тоот тушаалаар батлагдсан “Байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг 2024 оны 4-р сарын 5 ний өдөр нийт албан хаагч нарт танилцуулсан. 1.5. Эрэлч нохойн сургалтын төвийн төрийн тусгай албан хаагч нарт зориулж гаалийн ерөнхий газрын даргын 2016 оны 12-р сарын 2 ний өдрийн А/69 тоот тушаалаар батлагдсан “Гаалийн улсын байцаагчийн үйлчилгээний стандартын журам”-ийг 2024 оны 4-р сарын 8 ний өдөр танилцуулсан. 1.6. Гаалийн ерөнхий газрын 2019 оны 12-р сарын 3 ний өдрийн А/271 тоот тушаалаар батлагдсан “Гаалийн байгууллагын бэлгэ тэмдгийн тухай журам”-ыг албан хаагч нарт танилцуулсан. 1.7. 2024 оны 9-р сарын 19 ний өдөр гаалийн ерөнхий газрын даргын 2017 оны А/181 дүгээр тушаалаар батлагдсан “Гаалийн албаны эрэлч нохойн сонголт, нөхөн хангалт, бүртгэлжилтийг зохицуулах журам”-ийн дагуу гаалийн байгууллагад шинээр авах эрэлч нохдын материалыг бүрдүүлж 2024/63 тоот дотоод зурвасаар өмч хамгаалах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр		
--	--	--	--	--	--	--

				санхүү, хөрөнгө оруулалтын газар, аж ахуй, үйлчилгээний албанд хүсэлтийг хүргүүлсэн. 2. Хүрсэн түвшин: 2.1. 2024 онд хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор зохион байгуулсан эрх зүйн актуудыг танилцуулах ажилд эрэлч нохойн сургалтын төвд ажиллаж байгаа албан хаагч нарыг 100 хувь хамруулан мэдээ мэдээлэл хүргэж ажилласанаар хууль сахилт нэмэгдсэн. 2.2. Хөдөлмөр хамгааллын зааварчилгааг тогтмол мөрдүүлсэний үр дүнд 2024 оны 11-р сарын 30 ний өдрийн байдлаар эрэлч нохойн сургалтын төвийн ажлын байран дээр үйлдвэрийн осолд өртсөн албан хаагч байхгүй. 2.3. Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын дагуу шинээр ажилтан авах, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, тайлагнах, 7 хоног бүрийн даваа гаригт зохион байгуулдаг “шуурхай хуралдаан”-д оролцох, эрэлч нохойн сургалтын төвийн эзэмшил ашиглалтад байгаа байгууллагын өмчлөлийн эд хөрөнгө, техник хэрэгсэлийн бүрэн	
--	--	--	--	--	--

					бүтэн байдлыг хангаж албан хэрэгцээнд ашиглуулах, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, үнэлэх, дүгнэх, ажил, амралтын цагийн хуваарийг бүртгэл хөтлөн холбогдох албанд хүргүүлэх, албан хаагч нарыг шагнаж урамшуулах, тэтгэмж тусламж олгох зэрэг ажлуудын хэрэгжилтийг хангасан. 2024 оны холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилтийг ханган ажилласан.		
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Эрсдэлийн удирдлагыг оновчтой хэрэгжүүлж, эрсдэлийг таньж тогтооно.	1. Биелэлт: 2024 онд эрэлч нохойн сургалтын төвийн үйл ажиллагаанд нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Үүний үр дүнд 5 ширхэг эрсдэлийг тодорхойлж, үр дагавар, нөлөөллийн үнэлгээг хийж, магадлалын үнэлгээнүүдийг хийсэн. Үүнд: 1.1. R24/01 дугаартай - Хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж ажилаагүйгээс гарч болох эрсдэл. 1.2. R24/02 дугаартай - Нохойноос хүнд халдварладаг өвчин эмгэгүүд /Паразитууд, туузан хорхой, дугариг хорхой, хялгасан хорхой/. 1.3. R24/03 дугаартай - Эрэлч нохойтой ажиллахдаа аюулгүй байдлыг хангаж ажилаагүйгээс үүсч	01.01-12.31	100

				болох эрсдлүүд /нохойд хазуулах, үнэртүүлэхийг хориглосон химийн элемент үнэртүүлэх/ 1.4. R24/04 дугаартай - Мэдээлэл технологийн програм хангамжийн хүчин зүйл. 1.5. R24/05 дугаартай - Хувь хүн харилцааны доголдол гаргах эрсдэл гэж таньж тогтоосон. Энэхүү эрсдлүүдийг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажилласан.Үүнд: 1.6. Эрэлч нохойн сургалтын төвийн байр, сургалтын байр, нохойн үүр, сургалтын талбай, зугаалгын талбайд болон гаднах орчинд сард 1 удаа их цэвэрлэгээг зохион байгуулж ариутгал халдваргүйжүүлэлт хийдэг. 1.7. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах зорилгоор албан хаагч нарын ашигладаг компьютер тоног төхөөрөмжүүдийг нууц кодоор цоожилсон. Албан хаагч ээлжийн амралт авах аль эсвэл ажил ирэхгүй байх тохиолдолд гаалийн улсын ахлах байцаагч эсвэл төвийн даргад нууц кодыг дамжуулж өгөхөөр зааварчилсан. 1.8. Албаны ноходтой ойртож ажиллах үед өөрийгөө болон бусдын аюулгүй байдлыг хангах үүднээс шинээр ирсэн нохойд	
--	--	--	--	--	--

				хошуувч зүүлгэн сургалтын талбайд гаргах, шинээр томилогдсон албан хаагчид эхний ээлжинд хошуувчтай нохойг өгч сургалтын талбайд гаргуулах. Албан хаагч нарын нохой сургалттай холбоотой хувийн бэлтгэлийг хангуулах. 1.9. Эрэлч нохой сургалтын төвийн албан хаагчдад “ГААЛИЙН БАЙГУУЛЛАГЫН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН НИЙТЛЭГ ЗААВАРЧИЛГАА”-г танилцуулан өдөр бүр гарын үсэг зуруулж баталгаажуусан. 1.10. Гаалийн ерөнхий газрын санхүү, хөрөнгө оруулалтын газар болон аж ахуй, үйлчилгээний албанд "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11.5, 11.6 дахь заалтуудыг үндэслэн амь насны даатгалд хамруулах хүсэлтийг 2024/34 тоот дотоод зурвасаар хүргүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулан ажилласан. 2.Хүрсэн түвшин: 2023 онд эрэлч нохойн сургалтын төв нь үйл ажиллагаанд эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж байгаагүй. 2024 онд эрэлч нохойн сургалтын үйл ажиллагаанд нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн. Ажлын хүрээнд 5	
--	--	--	--	---	--

					эрсдэлийг таньж тогтоосон. Эрэлч нохойн сургалтын төвийн нэгжийн эрсдэлийн удирдлагын чиглэлээр сургалтад албан хаагч нар хамрагдаж байгаагүй. 2024 оны 9-р сарын 18 ний өдөр гаалийн ерөнхий газрын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, эрсдэлийн удирдлагын хэлтэс, дотоод хяналт, аюулгүй байдлын хэлтсийн хамтран зохион байгуулсан "Эрсдэлийн удирдлагын хэрэгжүүлэх онол, практикийн асуудал" уулзалт сургалт гаалийн улсын байцаагч А.Энх-Амгалан хамрагдсан. Сургалтын үр дүнд эрсдэлийг бууруулах хэд хэдэн арга хэмжээг тогтмол авч хэрэгжүүлснээр 2024 онд эрэлч нохойн сургалтын төвөөс үйлдвэрийн осол болон хөдөлмөрийн аюулгүй байдал хангаж ажиллахгүйгээс гарч болох эрсдэл, нохойноос хүнд халдварлах өвчин эмгэг, эрэлч нохойтой ажиллахдаа аюулгүй байдлыг хангаж ажиллахгүйгээс үүсэж болох эрсдэлд өртсөн албан хаагч байхгүй байна.		
9.	Үүрэг даалгаврын биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь бүрэн биелүүлж ажиллана.	1.Биелэлт: Захиргаа дотоод системийн үүрэг даалгавар дэд системээр 2024 онд ЗУГ-с 2 үүрэг даалгавар, ЭУХ-с 1 үүрэг даалгавар ХШҮДАГ-с 8	01.01-12.31	100

					зөвлөмж нийт 11 үүрэг даалгавар өгөгдсөн. Үүнээс: 1.1. 2023.12.28-2024.05.15 хүртэлх хугацаанд өгөгдсөн 7 зөвлөмж 1.2. 2024.04.10-2024.06.03 хүртэлх хугацаанд өгөгдсөн 1 зөвлөмж 1.3. 2024.03.06-2024.03.12-ны хүртэлх хугацаанд өгөгдсөн 1 үүрэг даалгавар 1.4. 2024.01.09-2024.11.30 хүртэлх хугацаанд өгөгдсөн 1 үүрэг даалгавар 1.5. 2024.08.26-2024.12.07-ны хүртэлх хугацаанд өгөгдсөн 1 үүрэг даалгаварын биелэлтүүдийг хугацаанд нь дүгнүүлэн ажилласан. 2. Хүрсэн түвшин: 2.1. 2024 оны 1 дүгээр сарын 1 ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл хугацаанд захиргаа дотоодын ажлын системээр дамжуулан өгөгдсөн 3 үүрэг даалгаварын биелэлтийг хугацаанд оруулж тайлагнасан. Үүнээс онлайн хурлын даалгавар 1, ёс зүйн днд хорооны хуралдаан 1, зөвлөмж 8 өгөгдсөнийг 100 хувь биелүүлсэн 2.2. Мөн хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас 2023 оны 01 дүгээр сарын 04 ний өдрийн №11 тоот дотоод зурвасаар өгөгдсөн		
--	--	--	--	--	---	--	--

					нийтлэг болон тусгай зөвлөмжүүдийн биелэлтийг ханган 2023 оны 06 дугаар сарын 21 ний дотор тайлагнасан. Захиргаа дотоод ажлын системээр өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлт 2024 оны 11-р сарын 30 ний байдлаар 100 хувьтай байгаа нь 2023 оны жилийн эцсээс 6,7 хувиар өссөн байна. 2024 онд захиргаа дотоод ажлын системээр 11 үүрэг даалгаварууд: 2.3. ХШҮДАГ-аас 2023.12.28-ний өдрөөс 2024.05.15-ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.4. ХШҮДАГ-аас 2023.12.28-ний өдрөөс 2024.05.15-ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.5. ХШҮДАГ-аас 2023.12.28-ний өдрөөс 2024.05.15-ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.6. ХШҮДАГ-аас 2024.12.28-ний өдрөөс 2024.05.15 -ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.7. ХШҮДАГ-аас 2023.12.28-ний өдрөөс 2024.05.15-ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.8. ХШҮДАГ-аас 2023.12.28-ний өдрөөс 2024.05.15-ний өдрийг		
--	--	--	--	--	--	--	--

					хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.9. ХШҮДАГ-аас 2023.12.28-ний өдрөөс 2024.05.15-ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 100 хувиар үнэлсэн. 2.10. ХШҮДАГ-аас 2024.04.10-ний өдрөөс 2024.06.03-ний өдрийг хүртэл өгөгдсөн зөвлөмжийн биелэлтийг 95 хувиар үнэлсэн. 2.11. ЗУГ-аас 2024.01.09-ны өдрөөс 2024.11.30-ны өдрийг хүртэл өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлтийг оруулсан. 2.12. ЗУГ-аас 2024.03.06-ны өдрөөс 2024.03.12-ны өдрийг хүртэл өгөгдсөн үүрэг даалгаварын биелэлтийг 100 хувиар дүгнэсэн. 2.13. ЭУХ-с 2024.08.26-ны өдрөөс 2024.12.07-ны өдөр хүртэлх өгөгдсөн үүрэг даалгаюарын биелэлтийг 100 хувиар дүгнэсэн. 2024 оны 11 дүгээр сарын 30 ний байдлаар эрэлч нохойн сургалтын сургалтын төвийн чиг үүрэгт хамааралтай өөрүүрэг даалгаварууд өгөгдөөгүй, шаардлагатай тохиолдолд хэрэгжилтийг ханган ажиллаж, хугацаанд нь тайлагнах болно.		
10.	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, оноогоор	-	Албан хаагч нарын ажлын	1.Биелэлт:	01.01-12.31	100

				цаг ашиглалт бүрэн байна.	1.1. Гаалийн ерөнхий газрын Эрэлч нохойн сургалтын төв нь ажилчид албан хаагчдын ирц болон ажлын цаг ашиглалтыг бүрэн биелүүлэн ханган ажиллаж байна. Эрэлч нохойн сургалтын төвийн албан хаагч нарын ажилдаа ирэх, тарах цагийг өдөр тутам тогтмол бүртгэж сард 2 удаа нэгтгэж гаалийн ерөнхий газрын дэргэдэх аж ахуй, үйлчилгээний албанд хүргүүлдэг. 1.2. Бүх нийтийн амралтын өдөр болох хагас бүтэн сайн өдрүүд, бүх нийтээр амардаг баяр ёслолын өдрүүдэд эрэлч нохойн сургалтын төвийн албан хаагч нар ээлжээр ажиллаж нохой хооллох, услах, салхилуулах ажлыг хийж гүйцэтгэдэг. 2. Хүрсэн түвшин: 2.1. Гаалийн ерөнхий газрын Эрэлч нохойн сургалтын төв нь ажилчид албан хаагчдын ирц болон ажлын цаг ашиглалтыг бүрэн биелүүлэн ханган ажиллаж байна. Эрэлч нохойн сургалтын төвийн албан хаагч нарын ажилдаа ирэх, тарах цагийг өдөр тутам тогтмол бүртгэж сард 2 удаа нэгтгэж гаалийн ерөнхий газрын дэргэдэх аж ахуй, үйлчилгээний албанд ЭНСТ-ийн даргаар хянуулж хүргүүлдэг.		
--	--	--	--	------------------------------	--	--	--

					2.2. Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 9.3.3 д Шаардлагатай тохиолдолд цагийн бүртгэл хөтөлдөг албан хаагчийг томилон давхар бүтгүүлж болно гэж заасныг үндэслэн эрэлч нохойн сургалтын төвийн гаалийн улсын байцаагч Т.Нандин-Эрдэнээр хөтлүүлдэг. Цагийн бүртгэлийн дэвтэрт эрэлч нохойн сургалтын төвийн дарга тогтмол хяналт тавьж ажилладаг. 2.3. Албан хаагч нарыг ажилд ирэх болгонд гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны 06 дугаар сарын 05 ний өдрийн А/107 тоот тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг зааварчилгаа"-г танилцуулан гарын үсгээр баталгаажуулдаг. 2.4. Долоо хоногийн амралтын өдөр болох хагас бүтэн сайн өдөр, бүх нийтээр амардаг баяр ёслолын өдрүүдэд эрэлч нохойн сургалтын төвийн албан хаагч нар ээлжээр ажиллаж нохой хооллох, услах, салхилуулах ажлыг ЭНСТ-ийн даргын гаргасан хувиарын дагуу хийж гүйцэтгэдэг.		
11.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	-	Харьяа гаалийн газар, хороодод эрэлч нохойн	1. Биелэлт: 1.1. Гаалийн ерөнхий газрын даргын 2024.03.22-ны өдрийн № А/185 тоот	01.01-12.31	100

				чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдад заавар, зөвлөмж өгнө. Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох чиглэлээр ГУБ нарыг үнэлгээний сургалтад хамруулна.	“Үнэлгээний хороо байгуулах” тушаалаар ЭНСТ-ын ГУАБ Я.Мөнхнасан үнэлгээний хорооны даргаар ажиллаж гаалийн байгууллагын эрэлч нохдын хэрэгцээнд зориулалтын хоол нийлүүлэх харьцуулсан тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан. tender.gov.mn цахим хуудсанд 2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр тендерийн урилгыг байршуулж 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр тендерийг зохион байгуулсан. 1.2. Гаалийн ерөнхий газрын даргын 2024.02.01-ны өдрийн № А/103 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ЭНСТ-ын ГУАБ Я.Мөнхнасан ажлын хэсэгт гишүүнээр орж ажилласан. 1.3. Гаалийн ерөнхий газрын зөрчилтэй тэмцэх газар, ОХУ-ын ХГА-ны КТЕГ-ны харьяа Сибирь болон Алс Дорнодын бүсийн хууль сахиулах газруудтай хамтарсан уулзалтанд ЭНСТ-ийн дарга Б. Наранбадрах оролцсон. 1.4. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03 ны өдрийн А/34 тоот ЭНСТ-ийн дарга Б.Наранбадрах, ГУБ		
--	--	--	--	--	--	--	--

					Н.Ганболд нар үнэлгээний ажилтан бэлтгэх сургалтад хамрагдсан. 1.5. Гаалийн ерөнхий газрын зөрчилтэй тэмцэх аюулгүй байдлын газрын дарга болон цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын дарга нарын хамтран баталсан "Мансууруулах бодисын хууль эргэлттэй тэмцэх олон улсын өдөр"-ийг Чингис Хаан Олон Улсын нисэх буудалд 2024 оны 06 дугаар сарын 26 ны өдөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гаалийн байгууллагаас оролцох нохдыг 2024 оны 06 дугаар сарын 18 ний өдрөөс эхлэн үзүүлэн тоглолтод бэлдсэн. 1.6. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг эрчимжүүлэх, эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтанд ашиглаж буй байдлыг сайжруулах ажлын хүрээнд Гаалийн байгууллагын 2024 оны 10 дугаар сарын 23-нд ЭНСТ-ийн дарга Харьяа гаалийн газар хороодын эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдын үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр хангах хүрээнд онлайн хурал хийгдсэн хурлаар өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах талаар сургалт хийсэн. ГЕГ-аас зохион байгуулсан мэргэжил суртачлах өдөрлөгт ЭНСТ-ийн албан хаагч нар		
--	--	--	--	--	--	--	--

					эрэлч нохойн хамт оролцож эрэлч нохойн үзүүлбэр үзүүлж олон нийтэд суртачилав. 2. Хүрсэн түвшин: 2.1. ГЕГ-ын 2024.03.22-ны өдрийн № А/185 тоот “Үнэлгээний хороо байгуулах” тушаалаар ЭНСТ-ын ГУАБ Я.Мөнхнасан үнэлгээний хорооны даргаар ажиллаж гаалийн байгууллагын эрэлч нохдын хэрэгцээнд зориулалтын хоол нийлүүлэх харьцуулсан тендерийн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулж нохой хоолоор хангагдсан. 2.2. ГЕГ-ын 2024.02.01-ны өдрийн № А/103 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” тушаалаар ЭНСТ-ын ГУАБ Я.Мөнхнасан ажлын хэсэгт гишүүнээр орж ажиллаж албан тушаалын тодорхойлтод судалгаа хийж мэргэжлийн индэкц өөрчлөл оруулах санал оруулсан. 2.3. ГЕГ-ын зөрчилтэй тэмцэх газар, ОХУ-ын ХГА-ны КТЕГ-ны харьяа Сибирь болон Алс Дорнодын бүсийн хууль сахиулах газруудтай хамтарсан уулзалтанд Эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б. Наранбадрах оролцсон. 2.4. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр,		
--	--	--	--	--	---	--	--

					нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03 ны өдрийн А/34 тоот эрэлч нохойн сургалтын төвийн дарга Б.Наранбадрах, ГУБ Н.Ганболд нар үнэлгээний ажилтан бэлтгэх сургалтад хамрагдаж төгссөн. 2.6. Гаалийн ерөнхий газрын зөрчилтэй тэмцэх аюулгүй байдлын газрын дарга болон цагдаагийн ерөнхий газрын хар тамхитай тэмцэх газрын дарга нарын хамтран баталсан "Мансууруулах бодисын хууль эргэлттэй тэмцэх олон улсын өдөр"-ийг Чингис Хаан Олон Улсын нисэх буудалд 2024 оны 06 дугаар сарын 26 ны өдөр зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөний дагуу гаалийн байгууллагаас оролцох нохдыг 2024 оны 06 дугаар сарын 18 ний өдрөөс эхлэн үзүүлэн тоглолтод бэлдсэн. 2.7. Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг эрчимжүүлэх, эрэлч нохойг гаалийн хяналт шалгалтанд ашиглаж буй байдлыг сайжруулах ажлын хүрээнд Гаалийн байгууллагын 2024 оны 10 дугаар сарын 23-нд ЭНСТ-ийн дарга Харьяа гаалийн газар хороодын эрэлч нохойн чиглэлээр ажиллаж байгаа албан хаагчдын үйл ажиллагааг удирдлага арга зүйгээр		
--	--	--	--	--	--	--	--

					хангах хүрээнд онлайн хурал хийгдсэн хурлаар өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангах талаар сургалт хийсэн. ГЕГ-аас зохион байгуулсан мэргэжил суртачлах өдөрлөгт ЭНСТ-ийн албан хаагч нар эрэлч нохойн хамт оролцож эрэлч нохойн үзүүлбэр үзүүлж олон нийтэд суртачилсан.		
--	--	--	--	--	---	--	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үндэсний мод тарих өдөртэй холбогдуулан гаалийн ерөнхий газрын албан хаагч нарын мод тарих ажлыг зохион байгуулах.	Хэрэгжилт гүйцэтгэлээр	-	Үндэсний мод тарих өдөртэй холбогдуулан мод тарих ажил зохион байгуулагдсан байна.	1. Гаалийн ерөнхий газрын удирдлагын зүгээс үүргийн дауу үндэсний мод тарих өдөртэй холбогдуулан гаалийн байгууллагын албан хаагч нарын мод ажлыг 2024 оны 05 дугаар сарын 18 ны өдөр Төв аймгийн Сэргэлэн сумын 4-р баг хөшигийн хөндийд байрлах гаалийн ерөнхий газрын дэргэдэх эрэлч нохойн сургалтын төвийн хашаанд зохион байгуулсан. Арга хэмжээнд Гаалийн ерөнхий газар, улаанбаатар хот дахь гаалийн газар, улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар, Чингис Хаан Олон Улсын нисэх буудал дахь гаалийн газруудын 100 гаруй албан хаагч гэр бүлийн хамт оролцож 200 орчим мод тарьсан. Тарьсан модыг арчилах, услах ажлыг эрэлч нохойн сургалтын төв хариуцан хийж байна. Арга хэмжээг гаалийн байгууллагын	01.01-12.31	100

					цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. ГААЛИЙН БАЙГУУЛЛАГА ТЭРБУМ МОД ТАРИХ АЯНД НЭГДЛЭЭ – Гаалийн ерөнхий газар (customs.gov.mn)		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	Хэрэгжилт, гүйцэтгэлээр, сургалтын тоогоор	-	Сургалтад хамрагдсан байна.	1. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 03 ны өдрийн А/34 тоот тушаалаар “Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/513, А/171 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Мэргэжлийн сургалтын байгууллагын төгсөгчийн чадамжийг үнэлэх, баталгаажуулах, гэрчилгээжүүлэх журам”-ын хэрэгжилтийг ханган чадамжийн үнэлгээг хийх эрх бүхий үнэлгээний ажилтан бэлтгэх хамрагдаж төгссөн. Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институтээс хөтлөгч, албаны нохой сургагч чиглэлээр ажиллах үнэлгээний ажилтаны эрхийг	01.01-12.31	100

					баталгаажуулж гэрчилгээ, үнэмлэх олгосон. 2. Улаанбаатар эрдэм их сургуульд “Бизнесийн удирдлага”-ын чиглэлээр магистрын зэрэг олгох сургалтад 2022 оноос эхлэн суралцсан. 2024 оны 05 дугаар сард төгсөлтийн шалгалтуудыг өгч тэнцсэн. Улаанбаатар эрдэм их сургуулийн ректорын 2024 оны 06-р сарын 04-ний өдрийн №58 тоот тушаалаар № 7202402114 дугаартай дипломоор Бизнесийн удирдлагын магистрын зэрэг олгосон.		
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	Хэрэгжилт, гүйцэтгэлээр,	-	Хууль эрх зүйн мэдлэг дээшилсэн, албан хаагчдад танилцуулж өдөр тутмын үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.	1. Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж дэргэдэх байгууллагуудаас дотоод зурвасаар ирсэн хууль, журмын төсөл хөтөлбөрүүдтэй тогтмол танилцаж, эрэлч нохойн сургалтын төвийн чиг үүрэгт хамаарах хууль, дүрэм, журамд тогтмол санал хүргүүлэн ажилласан. Гаалийн ерөнхий газрын даргын баталсан дотооддоо дагаж мөрдөх эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангах үүднээс тогтмол бие даан судалж, өөрийн нэгжийн албан хаагч нарт танилцуулан ажилласан.	01.01-12.31	100

ТАЙЛАН ГАРГАСАН:

Эрэлч нохойн сургалтын төвийн
дарга
(Албан тушаал)

Б.Наранбадрах /...../ (Нэр, гарын үсэг)

2024.12.16.
(Огноо)

ГААЛИЙН УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ Я.МӨНХНАСАНГИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ
ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Эрэлч нохойн сургалтын төв

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх" зорилтыг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Албаны эрэлч нохойн амьдрах, сургах орчин нөхцөлийг сайжруулсан байдал	60	10	70	
2.	Албаны эрэлч нохойн үржүүлгийн талаар хийгдсэн ажил	60	10	70	
3.	Албаны чадамж бүхий эрэлч нохойн сургалт	60	10	70	
4.	Эрэлч нохой ашиглалтыг нэмэгдүүлэх, зерчил илрүүлэх чадварыг дээшлүүлэх талаар хэрэгжүүлсэн арга хэмжээ	60	10	70	
5.	Бусад байгууллагатай хамтран ажилласан байдал	60	10	70	
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	60	10	70	
7.	Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн актын хэрэгжилт	60	10	70	
8.	Нэгжийн эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	60	10	70	
9.	Үүрэг даалгаврын биелэлт	60	10	70	
10.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	60	10	70	
11.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4
1.	Төрийн албаны тухай хуулийн 29.1-т заасан богино болон дунд хугацааны сургалтад хамрагдах	73	11	
2.	Шинээр гарсан хууль, тогтоол, журам, зааврыг тухай бүр бие даан судалж, хууль эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх	100	15	
Дундаж оноо:			13	

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	7	
2.	Асуудал шийдвэрлэх	6	
3.	Хариуцлагатай байдал	7	
4.	Дүн шинжилгээ хийх	5	
5.	Ажлын цаг ашиглалт	7	
Дундаж оноо:		6.4	

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2
1.	Хандлага, ёс зүй	8
2.	Багаар ажиллах	8
3.	Харилцаа	8
Дундаж оноо:		8

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	70

2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	13
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	6.4
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		97.4

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Эрэлч нохойн сургалтын төвийн дарга

.....
(Б.Наранбадрах)
..... (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

зөвшөөрсөн:

Гаалийн улсын ахлах байцаагч

.....
(Я.Мөнхнасан)
..... (огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

.....
(Г.Энхтайван)
2020.12.24 (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн гаалийн улсын ахлах байцаагч

.....
(Ө.Тэгшээ)
2024.12.20 (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга

.....
(Р.Отгонжаргал)
..... (огноо)